



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 640

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.3, 269 дүгээр тогтоолын 2, 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын улсын үндэсний номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон нийт 26,500,000.00 (хорин зургаан сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 3,262,500.31 (гурван сая хоёр зуун жаран хоёр мянга таван зуун төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монголын улсын үндэсний номын сангийн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


3.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД



0001

Төрийн амчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны дугаар сарын 04-ны
өдөрийн дугаар тогтоолын хавсралт



Монголын улсын үндэсний номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэгдэй, нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах автомашинны жагсаалт

Д/Д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Barahcpih vhe Хүчинчилж ашиглаж бий	YnA3R43n eptor /төгрөгөөр/	GOCORTPIH 3apPAz Cp3eeh XyA3R43n eptor /torgooy/		Yhnh, cahan XyA3R43n eptor /torgooy/
						YnA3R43n eptor /torgooy/	GOCORTPIH 3apPAz Cp3eeh XyA3R43n eptor /torgooy/	
1	MMC Делика, 97-76 УБТ, суудлын, арагт: РО4W-0004579	1995/2008	133093	12,000,000.00	12,000,000.00	-	-	3,000,000.00
2	Ниссан Х-Трейл , 27-32 УНМ, суудлын, арагт:НТ30011682,	2002/2011	211890	14,500,000.00	11,237,499.69	3,262,500.31	-	3,500,000.00
				26,500,000.00	23,237,499.69	3,262,500.31	-	6,500,000.00
				(хорин зургаан сая таван зуун мянган)	(хорин гурван сая хоёр зуун гучин долоон мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг жаран есөн мөнгө)	(гурван сая хоёр зуун жаран хоёр мянга таван зуун төгрөг гучин нэгэн мөнгө)	- (зургаан сая таван зуун мянган)	
				Нийт дүн				